



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 6 сарын 22 едөр

Дугаар 130

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 7.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Роялкашимер ХААБ” ХХК-ийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгасантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК /Х.Баатар/, “Роялкашимер ХААБ” ХХК /Ц.Гэрэлт-Од/-д тус тус үүрэг болгосугай.

2. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгасантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК /Х.Баатар/, “Роялкашимер ХААБ” ХХК /Ц.Гэрэлт-Од/-д тус тус үүрэг болгосугай.

1/ Харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журамд заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлэх;

3/ Энэхүү тогтоолтой нийцүүлэн холбогдох дүрэм, журам, биржийн арилжааны системд зохих вөрчлөлтийг оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд сар бүрийн эцэст тогтмол төвлөрүүлж ажиллах;

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-ид даалгасугай.

ДАРГА

СДАВААСҮРЭН

